



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/А65

Булган сум

**Ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн
Мэдээлэл зүйн танхимын тоног төхөөрөмж
хүлээж авах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэн ажиллах “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Код бичих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Булган сумын Ерөнхий боловсролын гуравдугаар сургуульд Мэдээлэл зүйн танхимын тоног төхөөрөмж, техникийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: З.Батбагана (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд: Э.Мөнх-Очир (Булган сумын гуравдугаар сургуулийн Мэдээлэл зүйн багш)
Нарийн бичгийн дарга: Д.Дэжидбаа (Булган сумын гуравдугаар сургуулийн Математик, мэдээллийн технологийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч)

2. Мэдээлэл зүйн танхимд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэлийг техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч, актыг үйлдэх ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (З.Батбагана)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Сугаа Ажил 2025 өдөр бүр

6325011165